



Бурхан бол Өгөөмөр Залбирлын Хуудас

Огноо:

- Залбирлын хуудсыг хүн бүрт хувилж өгнө
- Цагтаа эхэлж, цагтаа дуусгана
- Хэрэгтэй зүйлс: Библи, *Ээжүүд Хамтдаа Залбирах нь Товхимол*, үзэг.

♥ **Магтаал** — Бурханыг **Хэн болохынх нь** төлөө, Түүний мөн чанар, Түүний нэр эсвэл Түүний зан чанарынх нь төлөө магтана. Энэ мөчид залбирлын хариулт болон залбирлын хүсэлтүүдээ хэлэхгүй.

Мөн чанар: Бурхан бол Өгөөмөр

Attribute: God Is Generous

Тодорхойлолт: Бялхам ерөөл, хангамжаар ивээдэг, Харамгүйгээр өгдөг Нэгэн.

Эшлэл(үүд):

- **Дэд хууль 2:7** Бурхан ЭЗЭН чинь гарын чин үйлс бүхэнд чамайг ивээж байсан. Энэ их цөлөөр туулахыг чинь мэдээд, өнгөрсөн дөчин жилийн турш ЭЗЭН Бурхан чинь чамтай хамт байснаар чи юугаар ч дутаагүй” гэж хэл” гэсэн.
- **Дуулал 65:9-13** Та газар дэлхийд айлчилж, түүнийг бялхуулдаг. Та түүнийг ихэд баяжуулдаг. Бурханы урсгал усаар дүүрэн байдаг. Та газрыг ийнхүү зэхэхдээ тэдний үр тариаг бэлтгэдэг. Та түүний шанг арвинаар усан нурууг нь тэгшилж, Та зүсэр бороогоор түүнийг дэвтээн ургахыг нь ч ерөөнө. Та ээлтэй жилдээ титэм өмсгөн Таны мөрөөр тос цавдмуй. Хээр талын бэлчээрүүд ч цавдуулж, толгод баяр баясгалангаар хучигддаг. Нугыг хонин сүрэг нөмөрч, хөндийнүүд үр тариагаар хучигджээ. Баясгалантай хашгиралтууд, тэд дуулалдмуй!
- **Иохан 10:10** Хулгайч зөвхөн хулгайлан, алж сүйтгэхээр ирдэг. Би тэднийг амьтай, бялхсан амьтай байлгахын тулд ирсэн билээ.
- **Ром 8:32** Тэр Өөрийн Хүүгээ үл өршөөж, харин Түүнийг бид бүхний төлөө тушаасан юм. Тэгвэл Тэр яаж бүх юмыг Түүний хамт бидэнд сул өгөхгүй байх билээ?

♥ **Гэмшил** — Уучилж өршөөдөг Бурханд хандан гэм нүглээ чимээгүй улайх.

Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ. 1 Иохан 1:9

♥ **Талархал** — **Хийсэн зүйлийх нь** төлөө Бурханд талархах. Энэ цагт залбирлын хүсэлтээ хэлэхгүй байх хэрэгтэй. *Бүх зүйлд талархлаа илэрхийл. Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс доторх Бурханы хүсэл мөн. 1 Тесалоник 5:18*

♥ **Зуучлан залбирал** — Бурханы өмнө ирж бусдын төлөө залбирах. Хоёр буюу гурваар бүлэгт хуваагдана.

Өөрсдийн хүүхдүүдийн төлөө — Ээж бүр нэг хүүхэд сонгоно. (Библийн ишлэлээр залбирах/Залбирлын тодорхой хүсэлт)

Эшлэл(үүд): Дуулал 112:5; Сургаалт үгс 11:25

Библийн эшлэлээр залбирах:

Өө Аав минь, (Хүүхдийн нэр)-дээр сайн сайхан зүйлс ирэхийн тулд тэрээр нигүүлсэнгүй байж, өгөөмрөөр зээлүүлдэг, шүүхэд хэргээ батлуулдаг байхад туслаач. (Хүүхдийн нэр) өгөөмөр ерөөлийн хүн байснаар дэвжин дээшилж; бусдыг тэнхрүүлсэнээр өөрөө тэнхрэх болно.

Залбирлын тодорхой хүсэлт:

Багш/Ажилчид (нэгийг сонгоно): Багш/Ажилтаны төлөө залбирах нэг эшлэл сонго. Дараа нь тодорхой нэг хүсэлтийн дагуу залбирна.

- Эзэн минь ээ Та _____-ний нүдийг нээж, түүнийг харанхуйгаас гэрэл уруу, Сатаны эрхшээлээс Бурхан уруу эргүүлээч. Тэгснээрээ тэд Таньд итгэх итгэлээр ариусгагдсан хүмүүсийн дунд нүглийн уучлал ба өвийг хүртэх болно. *Үйлс 26:18*
- Өө Аав минь, _____-дээр сайн сайхан зүйлс ирэхийн тулд тэрээр нигүүлсэнгүй байж, өгөөмрөөр зээлүүлдэг, шүүхэд хэргээ батлуулдаг байхад туслаач. _____ өгөөмөр ерөөлийн хүн байснаар дэвжин дээшилж; бусдыг тэнхрүүлсэнээр өөрөө тэнхрэг. *Дуулал 112:5; Сургаалт үгс 11:25*

Сургуулийн төлөө залбирах – Сургуулийн орчинд сэргэлт ирж, сүнсний хараа өгөгдөхийн төлөө (цаг байвал хамгаалалт гэх мэт өөр бусад сэдвүүдийн төлөө)

Ээжүүд Хамтдаа Залбирах нь үйлчлэлийн төлөө залбирах — Сургууль бүрийг залбирлаар хучих; үйлчлэлийг хамгаалж өө сэвгүй, цэвэр ариунаар хадгалах.

Бүлэгт залбирсан бүхэн зөвхөн бүлэг дотроо л үлдэх ёстойг анхаараарай!